



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт эрс нэмэгдсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹1.1, 27¹1.4 дэх заалтыг үндэслэн Улсын онцгой комиссоос ТОГТООХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан тохиолдлын тоо эрс нэмэгдэж, эмнэлгийн байгууллагын тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөц, орны тоо хүрэлцэхгүй болж, ачаалал нэмэгдсэнтэй холбогдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор АШУҮИС-ийн “Монгол-Японы эмнэлэг”, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Сэргээн засах клиник, Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төвийг коронавируст халдвараар өвчилсөн хөнгөн, хүндэвтэр, хүнд өвчтөнийг эмчлэх зориулалтаар 2021 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн ашиглаж, шаардагдах зардлыг шийдвэрлэхийг Улсын онцгой комиссын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн нарт даалгасугай.

2. Их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн оюутны дотуур байр, спорт заалыг эмнэлгийн зориулалтаар бэлтгэж, гэрээр эмчлэгдэж буй иргэдийг татан авч тусгаарлан эмчлэх арга хэмжээг 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн зохион байгуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян нарт үүрэг болгосугай.

3. Иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасалдалгүй шуурхай зохион байгуулах, халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор тээврийн хэрэгсэл, иргэдийн хөдөлгөөнд шаардлагатай зохицуулалт хийж, хязгаарлах арга хэмжээг бүх нийтийн бэлэн байдлын хугацаа дуусах хүртэлх хугацаанд үр дүнтэй зохион байгуулахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн эмнэлэг, сувилал, амралтын газар, зочид буудал, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн оюутны дотуур байр, спорт заал, хоол үйлдвэрлэлийн газар болон тэдгээрийн хүн хүч, багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан тохиолдлыг тусгаарлан

эмчлэх зориулалтаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дайчлан татан оролцуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.

5. Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан тохиолдлыг тусгаарлан эмчлэхэд шаардагдах зардлын тооцоог гаргахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд Н.Уртнасан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын дарга нарт, зардлын тооцоог нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхийг Улсын онцгой комиссын орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Ж.Амгалан нарт үүрэг болгосугай.

6. Уул уурхайн компанийн ажилчдын батлагдсан болон сэжигтэй тохиолдлыг эмнэлгийн байгууллагад шилжүүлэх, түүний ойрын хавьтлыг болон ээлжийн бүрэлдэхүүнийг тусгаарлахтай холбоотой асуудлыг Улсын онцгой комиссын Шуурхай штабын зөвшөөрлөөр шийдвэрлэж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгасугай.


7. Тусгаарлан эмчлэх зориулалтаар ашиглаж байгаа байрны эрүүл ахуй, халдваргүйтгэл, аюулгүй байдлыг ханган, хяналт тавьж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Н.Цогбадрах, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд нарт даалгасугай.

8. "Спутник V" вакцины хадгалалтын горим, тээвэрлэлтийн талаар Улсын онцгой комиссын дараагийн хуралдаанд танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод даалгасугай.

9. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны мн/203 дугаар тогтоолд заасан хугацаанд 2020 оны нэгдүгээр ээлжээр татагдсан хугацаат цэргийн албан хаагчдыг халах, 2021 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага зохион байгуулах талаар Улсын онцгой комиссоос тогтоол гарган, хэрэгжилтийг ханган ажиллахыг Батлан хамгаалахын сайд, Улсын онцгой комиссын орлогч дарга Г.Сайханбаяр, Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Ж.Амгалан нарт даалгасугай.

10. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Ж.Амгалан, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

УХА0168